

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2015 оны 09 дүгээр сарын 30-нд болов. Тус хурлаар Хяналтын зөвлөлийн гишүүн Ч.Энхбаатарын Монголбанкинд үүссэн өр, авлага, түүний шалтгаан, барагдуулах талаар сүүлчийн 4 жилд хийсэн ажилтай танилцсан талаарх сонголт, Тамгын газраас Хяналтын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг 2 дугаар улирлын байдлаар гаргаж ирүүлсэн тайланг сонсож хэлэлцэв.

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан том өр авлагын үүссэн нөхцөл байдал, төлөгдөөгүй байгаа шалтгааныг нарийвчлан судалж, авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх, төлөгдөх найдваргүй болсон зарим авлагыг хууль, эрх зүйн зохих актын дагуу тодорхой эх үүсвэрээр хаах боломжийг судлан хэрэгжүүлэх, Монголбанкны системийн болон дотоод үйл ажиллагаанаас шалтгаалан шинээр өр авлага үүсэх арга зам, бүх нүх сүвийг хааж ажиллах, өр авлага барагдуулах ажлыг цаашид Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөмж болгосон байна. Хяналтын зөвлөлөөс гаргасан шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгч болон УИХ-ын Байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ